

**РТТ ХХК**

**ДУГУЙ ЗАСВАР**

**РЕМЕНЬ ЗАСВАР**

**СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨ**

**ЭЛЭГДЭЛ ХАМГААЛАЛ**



РЕЗИН ТЕХНИК ТЕХНОЛОГИ



**ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТАНИЛЦУУЛГА**

РТТ ХХК нь РЕЗИНЭН ЭДЛЭЛ-ийн засвар, үйлчилгээний салбарт 1998 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй 100% дотоодын хөрөнгө оруулалттай байгууллага юм. Бид R57 хүртэлх хэмжээтэй бүх төрлийн дугуйн засвар, конвейерийн туузны засвар, үйлчилгээ болон элэгдэл хамгааллын үйлчилгээг өөрийн болон харилцагчийн ажлын байранд үзүүлдэг тусгай мэргэжлийн баг, хамт олон.

Засвар, үйлчилгээг гардан гүйцэтгэхийн сацуу бид Германы РЕМА ТИП ТОП брендийн бүх төрлийн засварын материалыг зах зээлд нийлүүлдэг. Мөн харилцагч, хамтрагч байгууллагуудынхаа засварын багийн инженер, техникийн ажилтнуудыг чадавхижуулах мэргэжлийн сургалтуудыг Монгол улсдаа болон Германы РЕМА ТИП ТОП ACADEMY-ын сургалтын төвд явуулдаг.



РТТ ХХК нь 1923 онд үүсгэн байгуулагдсан Германы РЕМА ТИП ТОП ХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч, сервис партнераар 1998 оноос хойш ажиллаж байна.



РЕМА ТИП ТОП ХК-ийн олон улсын техникийн сертификатжуулалтын зөвлөлийн шийдвэрээр манай ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ-ийн баг хамт олон засварын мэдлэг, чанарын үзүүлэлтээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "OTR дугуй засварын мэргэжлийн байгууллага" сертификатыг 2023 онд авсан.



## ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ

**RE** new  
pair  
use

**REnew - REpair - REuse** зарчмын дагуу ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ нь нарны цахилгаан үүсгүүрээр үйлдвэрлэсэн **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ**-ийг ашиглаж, эвдэрч гэмтсэн резинэн эд ангиудыг, нэн ялангуяа бүх төрлийн дугуйг **ЗАСВАРЛАЖ, ДАХИН АШИГЛАХ** нөхцлийг бүрдүүлдэг. Ингэснээр бид манай улсад дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг бууруулах үйлсэд хүчин зүтгэж, байгаль дэлхийг хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулж буй **НОГООН БИЗНЕС ЭРХЛЭГЧ** байгууллагуудын нэг байж чаддаг.



▲ Нийт 1.510 м<sup>2</sup> талбай бүхий хоёр засварын заал




▲ 23 м хүртэл урттай ачааны машин орох боломжтой ачиж, буулгах хэсэг




▲ R57 хүртэлх хэмжээтэй бүх төрлийн дугуй засварлах Thermopress EM I болон Thermopress EM II халуун дарлагын машинууд



▲ Испани улсын GN брендийн 5 тн даац бүхий гүүрэн кран



▲ R49-R57 хэмжээтэй дугуй засварын моторт ажлын тавцан



▲ R35 хүртэлх хэмжээтэй дугуйг задлаж, угсрах алсын удирдлагатай бүрэн автомат PROMAXX машин

Бид харилцагчийн уурхайн талбар, ажлын байранд очиж дугуйг засварлах боломжтой эсэхийг ангилан ялгах үйлчилгээ үзүүлдэг.



## ДУГУЙ ЗАСВАР ба ҮЙЛЧИЛГЭЭ

РТТ ХХК нь 2014 оноос эхлэн дугуй засвар болон түүний дагалдах үйлчилгээг РЕМА ТИП ТОП технологийн дагуу олон улсын стандартыг хангасан ажлын орчинд, мэргэжлийн түвшинд үзүүлж байна. Манай засварын баг уул уурхайн хүнд даацын, хөдөө аж ахуйн тусгай зориулалтын, газар шорооны машин механизмын зэрэг R57 хүртэлх хэмжээтэй бүх төрлийн ОTR/ЕМ дугуйнуудыг чанарын өндөр түвшинд 2.000 мото/цаг хүртэлх баталгаат хугацааг олгож өөрийн засварын төвд болон харилцагчийн ажлын байранд очиж засварладаг олон улсын сертификат бүхий хамт олон.

2023.12.12-ны байдлаар бидний засварласан 50/80 R57 хэмжээтэй MICHELIN брэндийн дугуй зассанаас хойш 4.627 мото/цаг, 33.00 R51 хэмжээтэй BRIDGESTONE дугуй 5.400 мото/цаг ашиглагдсан амжилт бүртгэгдээд байгаа нь бидний бас нэгэн бахархал юм.



▲ ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ нь орчин үеийн өндөр хүчин чадал бүхий багаж, тоног төхөөрөмжүүдээр бүрэн тоноглогдсон тул олон ажлыг зэрэг гүйцэтгэх хүчин чадалтай



- ▲ Thermopress ECONOMY TP II, Thermopress EM I, Thermopress EM II халуун дарлагын машинуудыг ашиглан олон төрлийн дугуйнуудыг засварлах хүчин чадалтай.



- ▲ R57 хүртэлх хэмжээтэй дугуй засварын үйлчилгээ

Хөдөө аж ахуй,  
газар тариалангийн  
тусгай зориулалтын  
дугуйн засвар, үйлчилгээ



- ▲ R63 хүртэлх хэмжээтэй бүх төрлийн дугуйг засварлах боломжтой эсэхийг ажлын байранд очиж шалгах, үзлэг хийх үйлчилгээ.



## КОНВЕЙЕРИЙН ТУУЗ ЗАСВАР ба ҮЙЛЧИЛГЭЭ


- ▲ Конвейерийн туузыг хүйтэн аргаар холбох үйлчилгээ.  
Уулс Заамар ХХК, Төв аймаг, Заамар сум

РТТ ХХК-ийн засварын баг харилцагч байгууллагын захиалгаар бүх төрлийн ЕР үе бүхий конвейерийн туузыг ажлын талбар дахь конвейерийн систем дээр халуун болон хүйтэн аргаар шинээр холбох, засварлах үйлчилгээг үзүүлдэг. Мөн өөрийн засварын байранд бүх төрлийн конвейерийн туузыг захиалгат хэмжээгээр уртасгах, богиносгох, тайрах болон холболтонд бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэдэг.



- ▲ Конвейерийн туузын холболтын заавар, зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ.  
Алтайн Хүдэр ХХК, Говь-Алтай аймаг, Цээл сум

Конвейерийн туузыг  
хүйтэн аргаар холбох  
үйлчилгээ.  
Премиум Билдинг  
Материалс ХХК,  
Улаанбаатар хот



Элеваторын шанагат  
конвейерийн туузыг  
богиносгон холбох үйлчилгээ.  
ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ,  
Улаанбаатар хот



Конвейерийн туузыг  
хүйтэн аргаар шинээр холбох  
үйлчилгээ.  
Сонголон Хайрхан ХХК,  
Дархан-Уул аймаг, Дархан хот




Гүний уурхайн конвейерийн  
туузыг халуун аргаар холбох  
үйлчилгээ. Оюу Толгой ХХК,  
Өмнөговь аймаг, Ханбогд сум

# ЭЛЭГДЭЛ ХАМГААЛАЛ

Германы РЕМА ТИП ТОП ХК нь 1923 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд дэлхийн 180 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг. Элэгдэл болон хими хамгааллын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын тэргүүлэгч компани юм. РТТ ХХК нь РЕМА ТИП ТОП ХК-ийн Монгол Улс дахь бүрэн эрхт төлөөлөгч, сервис партнеровн хувьд элэгдэл хамгааллын зориулалт бүхий бүх төрлийн химийн бүтээгдэхүүн, хуяг резинүүд болон багажыг ханган нийлүүлэхээс гадна засварын үйлчилгээ үзүүлдэг.

Бид өнөөдрийн байдлаар конвейерийн системийн бүх төрлийн хөтлөгч, хөтлөгдөгч болон чангалагч булнуудыг резинэн хуягаар шинээр бүрж, элэгдлээс хамгаалах засварыг үзүүлж байгаа. Ирээдүйд хүчин чадлаа нэмэгдүүлэн металл гадаргуун элсэн цэвэрлэгээ болон керамик хуягны засвар, үйлчилгээг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.



Хөтлөгч булыг конвейерийн систем дээр REMAGRIP 60/CN резинээр хуяглаж буй байдал

1600 мм өргөнтэй, 630мм голчтой хөтлөгч булыг 12 мм зузаантай REMAGRIP 60/CN резинээр хуяглахад бэлтгэн металл гадаргуун цэвэрлэгээг хийж буй байдал



Цементийн үйлдвэрийн +100°C хэмийн ажлын орчинд ашиглагддаг 800 мм голчтой, 800 мм өргөнтэй хөтлөгч булыг хүйтэн аргаар хуягласан байдал





Конвейерийн тууз засварын сургалтыг Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ил уурхайн талбайд зохион байгуулсан нь ил задгай орчинд тулгарч болох хүндрэлүүдийг хэрхэн даван туулах тухай зааварчилгааг өгч, чадварыг бэхжүүлэх сургалт байлаа.


## СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ

РТТ ХХК нь 1998 оноос хойш РЕМА ТИП ТОП брендийн засварын бүтээгдэхүүнийг Монгол улсын зах зээлд нийлүүлэхээс гадна худалдаалсан засварын материалын ашиглалтын тухай болон техникийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх технологийн сургалтуудыг зохион байгуулсаар байна. Өнөөдрийн байдлаар манай арвин туршлагатай сургалтын баг өөрийн ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ-д, харилцагчийн ажлын байранд болон Герман улс дахь РЕМА ТИП ТОП АКАДЕМИ-ийн сургалтын төвүүдэд OTR дугуй засварын болон бүх төрлийн (ЕР болон төмөр тросстой) конвейерийн туузны халуун болон хүйтэн аргын засвар сэдвүүдээр харилцагдынхаа 800 орчим инженер, техникийн ажилтнуудыг давхардсан тоогоор сургаж, мэргэшүүлээд байна.

Мэдлэг, чадвартай иргэд аливаа улс орны хөгжлийн гол тулгуур гэж бид итгэдэг учир өөрсдийн мэдлэг, чадварыг хуваалцахдаа үргэлж баяртай байдаг. Иймээс танай байгууллагад дээрх сэдвүүдээр сургалт шаардлагатай бол бидэнтэй хамтран ажиллахыг урьж байна.



➤ R57 хүртэлх хэмжээтэй OTR дугуйг засварлах сургалт. Монголын Алт ХХК, Өмнөговь аймаг, Гурвантэс сум



➤ Суудлын болон ачааны автомашины дугуйг засварлах сургалт. Баян Айраг Эксплорэйшн ХХК, Завхан аймаг, Дөрвөлжин сум



➤ “Конвейерийн даавуун үетэй резинэн туузыг хүйтэн аргаар холбох нь” сэдэвтэй сургалтын хүрээнд бид Цемент Шохой ТӨХК-ийн засварын багийнхантай хамтран 1200 мм өргөнтэй туузыг технологийн горимыг баримтлан, чанартай сайн холбох ажлыг гүйцэтгэв.



Суудлын болон ачааны автомашины дугуйг засварлах сургалт. Премиум Конкрет ХХК, ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ, Улаанбаатар хот

OTR дугуйн засвар болон ашиглалтын тухай сургалт. Тавантолгой Оператор Түншлэл, Өмнөговь аймаг, Цогтцэций сум



Засварчдын үр чадвар, мэдлэгийг дээшлүүлэх гадаад багштай дотоодын сургалт. ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ, Улаанбаатар хот

OTR дугуйнд засварын үзлэг шалгалт хийх тухай сургалт. Ти Ти Жи Ви Си Өү ХХК, Өмнөговь аймаг, Цогтцэций сум



1400 мм хүртэл өргөнтэй конвейерийн туузыг халуун аргаар холбох, засварлах онол, практик хосолсон сургалтыг бид өөрийн халуун дарлагын машиныг ашиглан явуулдаг.

Бид зохион байгуулж буй бүх сургалтаараа конвейерийн туузын болон дугуйн тухай онолын мэдлэгийг олгодог. Онолын мэдлэг нь зөв, найдвартай засварын үндэс юм. Онолын суурь ойлголт, мэдлэггүйгээр засварын алдааг хэрхэн залруулахыг мэдэхэд хүндрэлтэй.



Конвейерийн EP үетэй туузыг хэрхэн зөв шатлан зүсэх аргачлалыг манай мастер багш С. Галбаатар Дулааны Дөрөвдүгээр Цахилгаан Станц ТӨХК-ийн ажилтнуудад зааж буй нь.

Сургалтын практик хэсгийн эхэнд бид багаж төхөрөөмжтэй хэрхэн зөв харьцах тухай заавар, зөвлөмжийг өгдөг. Засварчин хүний амин сүнс сайн багажиндаа оршдог ч гэж үг бий.





РТТ ХХК нь РЕМА ТИП ТОП брендийн дугуй засвар, конвейерийн тууз засвар болон элэгдэл хамгааллын бүх төрлийн материал, багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийг Герман улсад байрлах үйлдвэр болон төв агуулахаас татан авчирч Монгол улсын зах зээл дээр өөрийн салбар дэлгүүрүүдээр худалдан борлуулдаг.




Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн дунд “ГЕРМАН НӨХӨӨС” нэрээр алдаршсан MADE IN GERMANY буюу Герман улсад үйлдвэрлэгдсэн дээд чанарын 100 гаруй нэр төрлийн дугуйны нөхөөсүүдийг худалдаалдаг.



Хэрэв Та бүхэн мэргэжлийн дугуй засварын үйл ажиллагааг өөрийн уурхай, үйлдвэр болон засварын газарт нэвтрүүлэх хүсэлтэй бол бид тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэхээс гадна мэргэжлийн сургалтыг дагалдуулан олгодог.



РЕМА ТИП ТОП ХК захиалагчийн шаардлага, хүсэлтийн дагуу tailor-made буюу конвейерийн халуун дарлагын REMAPRESS машинуудыг захиалгаар үйлдвэрлэн нийлүүлдэг.



Бид резинэн эдлэлийн засварын багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжүүдийг олон төрлийн сонголттойгоор бэлэн болон захиалгаар худалдаалж байна.



Италийн COFRA ХХК нь 1938 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд ажлын гутлын дэвшилтэт технологи, инновациар тэргүүлэгч компани юм. Та бүхэн манай дэлгүүрүүдээр үйлчлүүлэхдээ Италийн алдарт COFRA брендийн 60 гаруй загварын энгийн болон тусгай зориулалтын ажлын гутлуудаас сонголт хийгээрэй. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.facebook.com/COFRA Mongolia](https://www.facebook.com/COFRA Mongolia) хуудаснаас сонирхоно уу.



РЕЗИН ТЕХНИК ТЕХНОЛОГИ



### ТИП ТОП ЗАСВАРЫН ТӨВ

Ногоон зоорь 45  
Баянзүрх дүүрэг, 11-р хороо  
Улаанбаатар



### ТИП ТОП ТӨВ

Сансарын түннель  
Их тойруу 63,  
Баянзүрх дүүрэг, 3-р хороо  
Улаанбаатар



### ТИП ТОП БАРУУН САЛБАР

Мах Маркетын үүлзвар,  
Үйлдвэрийн баруун бүс 30 тоот  
“United Oil” төв, Баянгол дүүрэг  
20-р хороо, Улаанбаатар

2024



7000 1110, 9191 5746



info@rtt.mn



www.facebook.com/rttmon olia



www.rtt.mn